

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Бөөрөлзгөний суулгац. Техникийн ерөнхий шаардлага	MNS 6373 : 2013
Raspberry seedlings. General technical requirements	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор батлав

Энэ стандартыг 2013 оны 3 дугаар сар 29-ний өдрөөс эхлэнэ мөрдөнө.

## 1. ХАМРАХ БА ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

1.1 Энэхүү стандарт нь бөөрөлзгөний суулгац үржүүлэх, шалгаж хүлээн авах, савлах, борлуулах, импортлох, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд хамаарна.

1.2 Энэ стандартыг баталгаажсан технологийн дагуу бөөрөлзгөний суулгацыг үржүүлдэг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болон хяналт шалгалтын эрх бүхий байгууллагууд хэрэглэнэ.

1.3 Энэхүү стандарт нь бөөрөлзгөний үндэсний шижим, үрээр үржүүлсэн суулгацад хамаарахгүй.

## 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад дараах баримт бичгийг эш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас эш татаж хэрэглэнэ.

- MNS 4220:1994, Жигдийн тарьц, техникийн шаардлага,
- ГОСТ 13853:78, Яст болон үрт жимст модны үр, тариалалтын чанар. Техникийн нөхцөл,
- ГОСТ24835:81, Интоорын, тарьц суулгац, тариалалтын чанар,
- MNS 6250:2011, Чацарганы суулгац, техникийн шаардлага,
- MNS 6251:2011, Үхэр нүдний суулгац, техникийн шаардлага.

## 3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

### 3.1 Бөөрөлзгөний суулгац

Үржүүлгийн эх цэцэрлэгээс ургал эрхтнээр нь үржүүлэн гаргаж авсан, жимст цэцэрлэг байгуулахад зориулсан хоёр настай суулгац,

### 3.2 Жимст цэцэрлэг

Жимс хурааж авах зориулалттай цэцэрлэг,

### 3.3. Үржүүлгийн эх цэцэрлэг

Үржүүлэгт зориулан мөчир авахаар шигүү тариалсан цэцэрлэг,

### 3.4 Ургал эрхтнээр үржүүлсэн суулгац

Модлог болон ногоон мөчир, нахиа, үндэсний аль нэг хэсгээс таслан авч үржүүлсэн суулгац,

**3.5 Хоёр настай суулгац**

Ургал эрхтнээс нь авч эхний жил үндэслүүлж, дараа жил нь бойжуулгын талбарт тариалж торинуулсан суулгац,

**3.6 Үрийн суулгац**

Жимс авах зориулалттай эх цэцэрлэгээс хураасан бүрэн боловсорсон жимснээс авсан үрийг хатааж, хавар намар тарьж, дараа жил нь бойжуулж торниулсан хоёр настай суулгацыг хэлнэ.

**3.7 Бойжуулгын талбай**

Ногоон мөчир болон нугалаадсаар үндэслүүлсэн тарьцыг суулгац болтол нь ургуулах тусгайлан бэлтгэсэн талбай,

**3.8 Механик гэмтэл**

Мөчир, салаа эш, үндэс, холтсонд үүссэн шалбархай, хугарал, бяцрал, халцрал,

**3.9 Амь чийг**

Мөчир салаа эш, үндэс хорчийж, чийг алдагдлын шинж тэмдэг илрээгүй байдал,

**3.10 Суулгацын өндөр**

Үндэсний хүзүүнээс мөчрийн орой хүртэлх хэмжээ,

**3.11 Үндэсний хүзүү**

Үндэснээс ишинд шилжих зааг,

**3.12 Бөөрөлзгөний зэв**

*Phragmidium rubi-idgei* (DC) P.Karst мөөгөнцөрөөр үүсдэг өвчин. Өвчний шинж тэмдэг навчны дээд талд шар өнгийн, харин намар навчны доод гадаргууд улаан хүрэн, хар хүрэн өнгийн төвгөрүүсэх байдлаар илэрдэг.

**3.13 Бөөрөлзгөний антракноз**

*Gloeosporium venetum* sp. мөөгөнцөрөөр үүсдэг өвчин. Өвчний гадаад илрэл навч, мөчир дээр ягаан хүрэн эмжээртэй цагаан саарал өнгийн толбонууд үүсэх байдлаар илэрдэг. Хүчтэй өвчилсөн үед мөчир хатдаг.

**3.14 Навчны цагаан толбожилт**

*Septoria rubi westend* мөөгөнцөрөөр үүсдэг өвчин. Энэ өвчний шинж тэмдэг навч, мөчир дээр 2-оос 4 мм голчтой дугуй, улаан эмжээртэй цайвар бор хүрэн өнгийн толбонууд үүсэх байдлаар илэрнэ. Толбоны өнгө яваандаа цайж цайвар болох бөгөөд өвчин үүсгэгч мөөгөнцөр үржиж спор үүсэх үед хар өнгийн жижиг цэг бий болно. Хүчтэй өвчилсөн үед мөчир хатдаг.

**4. АНГИЛАЛ**

**4.1 Үржүүлж гарган авсан аргаас нь хамааруулж бөөрөлзгөний суулгацыг**

- ногоон мөчрийн,
- нугалаадсын,
- үрийн гэж 3 ангилна

**4.2** Ногоон мөчир болон нугалаадсын аргаар үржүүлж гарган авсан бөөрөлзгөний 2 настай суулгацыг жимст цэцэрлэг байгуулах зориулалтаар тариална.

**4.3** Бөөрөлзгөний үрээр үржүүлж гарган авсан суулгацыг шинэ сорт гаргахад ашиглана.

## 5. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

**5.1** Бөөрөлзгөний суулгацыг баталсан технологийн зааврыг баримтлан үржүүлнэ.

**5.2** Бөөрөлзгөний бөөрөлзгөний эх цэцэрлэгт сортын хянан баталгаа хийсэн байвал зохино.

**5.3** Бөөрөлзгөний суулгац нь тухайлсан сортын шинж чанараа бүрэн хадгалсан бусад **сорт нь тодорхой байна.**

**5.4** Бөөрөлзгөний жимст цэцэрлэг болон үржүүлгийн эх цэцэрлэг байгуулахад ногоон мөчир болон нугалаадсаар үржүүлсэн хоёр настай I ба II-р зэргийн суулгацыг тариална.

**5.5** Бөөрөлзгөний суулгацын гадаад шинж тэмдэгийн үзүүлэлтүүд дараах хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байвал зохино.

### Бөөрөлзгөний суулгацын чанарын болон гадаад шинж тэмдэгийн үзүүлэлтүүд

д/д	Үзүүлэлт	Суулгацын шинж тэмдэг	Зэрэг	
			I	II
Үндэсний систем				
1	Үндэсний урт	см-ээс багагүй, сахлаг	40	30
2	голч	см-ээс багагүй	0,5	0,3
3	өнгө	Хүрэн саарал		
Газрын дээрх хэсэг				
1	Мөчрийн тоо	ш-ээс цөөнгүй	2	1
2	урт	см-ээс багагүй	50	40
3	голч	см-ээс багагүй	0,8	0,6
4	өнгө	Бор саарал		
5	Гадаад байдал	Үндсэн салаа мөчрийн гадаргуу бага зэрэг өргөстэй, нахиа шалбарч гэмтээгүй, үндэс харлаагүй, амь чийгтэй		
6	Зэв, антракноз, цагаан толбожилт зэрэг халдварлалт,	Илрэх ёсгүй		
7	Бөөс, хачиг зэрэг хөнөөлт шавьжийн халдварлалт	Илрэх ёсгүй		

ТАЙЛБАР1: Бөөрөлзгөний 2-р зэргийн шаардлагад хүрэхгүй суулгацыг бойжуулгын талбайд дахин тарина.

## 6. ДЭЭЖ АВАХ

## **MNS 6373 : 2013**

Суулгацын стандартын I, II-р зэрэгт заасан үзүүлэлтийг баримтлан нийт суулгацын 10%-иас хэтрэхгүй механик гэмтэлтэй байхыг зөвшөөрнө.

### **7. ШАЛГАЖ ХҮЛЭЭЖ АВАХ**

**7.1** Бөөрөлзгөний суулгацыг хавар тарихын өмнө буюу 5 сарын эхний арав хоногт, намар 10 сарын дунд арав хоногт багтаан шалгана.

**7.2** Суулгацын өндрийг шугам, голчийг штангенциркулиар хэмжинэ.

**7.3** Суулгацын өвчин, хортон шавьжинд нэрвэгдсэн байдлыг MNS 2783:1979 “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Мөөгөнцөрийн өвчнийг илрүүлэх арга”, MNS 2784:2007 “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн. Бактерийн гаралтай өвчнийг илрүүлэх арга”, MNS 2782:79 “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Хортон шавьжийг илрүүлэх арга” стандартуудын дагуу тус тус тодорхойлно.

### **8. САВЛАЛТ, ШОШГОЛОЛТ**

**8.1** Тухайн багцыг тээвэрлэхэд зориулан үндсийг гадны нөлөөллөөс бүрэн хамгаалах хэмжээний нийлэг хальс, таар шуудайн дээр чийглэсэн үртсийг жигд тараагаад, суулгацын үндсийг шороон зуурмагт хутгаж үзүүрийг нэг тийш нь харуулж тавиад өөр хоорондоо үрж холхихгүйгээр модны үртэс буюу шороогоор хөдөлгөөнгүй чигжисний дараа битүүлэн ороож бооно.

**8.2** Багцалж боосон суулгацыг дахин гадуур нь тааран шуудайнд савлана.

**8.3** Суулгацыг 50 буюу 100 ширхэгээр багцлан савлаж шошгыг тээвэрлэлтийн үед тасарч гээгдэхээс хамгаалан боодлын гадна ба дотор талд зүүнэ.

а/ Боодлын дотор зүүх шошгыг 7 см урт, 5 см өргөн модон юмуу зузаан цаасаар хийж дээр нь зөвхөн сортын нэрийг бичнэ.

б/ Боодлын гадна зүүх шошгыг 10 см урт, 8 см өргөн хэмжээтэй хийнэ. Шошгыг баларч арилахаас хамгаалсан байна.

**8.4** Багцалж боосон суулгацанд дараах мэдээлэл бүхий шошго, зааврыг дагалдуулна.

- Суулгац үйлдвэрлэгч байгууллага, аж ахуй нэгж, иргэний нэр, хаяг,
- Стандартын дугаар, тэмдэглэгээ,
- Сортын нэр, зэрэг
- Суулгацын тоо, ширхэг,
- Хадгалах хугацаа, нөхцөл,
- Тарьж ургуулсан он,
- Тарьж суулгах, заавар зөвлөмж.

### **9. ХАДГАЛАЛТ**

**9.1** Мод үржүүлгийн газраас авсан суулгацыг тарих хүртэл түр хугацаагаар хадгалах тохиолдолд суулгацын үндэсний хэсгийг 15-аас 20 см хүртэл зузаан үетэй чийгтэй шороогоор булж хадгална.

**9.2** Намар хүлээж авсан суулгацыг өвөлжүүлэх бол 30-аас 40 см гүн шуудууг салхины хөндлөн чиглэлд татаж суулгацыг шуудуундаа салхины ноёлох зүгийн дагуу тараан налуулж эгнүүлэн тавиад үндэсний хэсгийн 30-аас 40 см зузаан хар шороогоор булж ханатал усалж хадгална.

**9.3** Хадгалалтын хугацаанд мэрэгчид болон мал, амьтад суулгацыг гэмтээхээс хамгаалж шуудууны эргэн тойронд нарийн тороор хаших, хор, өгөөш тавих, ба цас ормогц хөрсний гадаргуу дээр ил байгаа иш, мөчрийг цасаар нягтруулан дарна.

## **10. ТЭЭВЭРЛЭЛТ**

**10.1** Савласан суулгацыг бүх төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхдээ босоо байдлаар эгнүүлэн тавьж доор нь 10-аас 15 см зузаан зөөлөвчтэй ачих бөгөөд боодлын хоорондох зай завсарт чийгтэй үртэс бүхий шороогоор чигжиж дүүргэнэ. Хол тээвэрлэх тохиолдолд үндсийг тогтмол чийглэж хатахаас хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай.

**10.2** Савласан суулгацыг нарны шууд тусгалаас хамгаалж сэрүүн нөхцөлд тээвэрлэнэ

**10.3** Савласан суулгацыг хэт хүнд зүйлээр дарж бяцлах, уут задарч үндэс ил гарахаас сэрэмжлэх, шатах дэлбэрэх, бохирдуулах бодистой хамт тээвэрлэхийг хориглоно.

**10.4** Тээвэрлэлтийн нэг удаагийн үргэжлэх хугацаа 4 хоногоос хэтрэхгүй байна.

**ТӨГСӨВ.**